СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн 99,6 хувь нь нийт мэдээлвэл зохих мэдээллийн 80,9 хувийг мэдээлсэн байна.





Сүхбаатар сум 2016 он

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын харьяа Сэлэнгэ аймгийн Аудитын газар

Тэргүүлэх аудитор
Ч.Энхтуяа

Аудитын менежер
Б.Батмөнх

Ахлах аудитор
С.Бат-Эрдэнэ
Б.Наранчимэг

Аудитор
Ц Отгонбаяр.
Б.Эрдэнэзул

Шинжээч
С.Баасансүрэн
Ц.Уртнасан
Э.Эрдэнэзул
А.Дашбат
Ж.Цогт

2016 оны 11-12 сар

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70362442, 70363036 дугаарын утас, 70363040 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:
Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум аймгийн ЗДТГ-ын байрны өргөтгөлд

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....
Аудит хийх үндэслэл.....
Аудитын зорилт.....
Аудитын хамрах хүрээ.....
Арга зүй.....
Шалгуур үзүүлэлт, хугацаа.....
Ерөнхий мэдээлэл.....

БҮЛЭГ.1 ***Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд бүрэн хэрэгжүүлж байгаа эсэх,***
1.1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан байгууллагууд бүрэн хамрагдаж байна уу?
1.2. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т заасан байгууллагууд бүрэн хамрагдаж байна уу?
1.3. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан байгууллагууд бүрэн хамрагдаж байна уу?
1.4. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасан байгууллагууд бүрэн хамрагдаж байна уу?
1.5. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан байгууллагууд бүрэн хамрагдаж байна уу?

БҮЛЭГ.2 ***Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд 6 дугаар зүйлд заасан мэдээллийг мэдээлж байгаа эсэх,***
2.1. 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг тогтмол мэдээлсэн үү?
2.2. 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.4-т заасан мэдээллийг 7 хоногийн дотор мэдээлсэн үү?
2.3. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 6 дугаар зүйлийн 6.5-д заасан мэдээллийг мэдээлсэн үү?
2.4. 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийг 7 хоногийн дотор мэдээлсэн үү?
2.5. 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.9-д заасан мэдээллийг журмын дагуу мэдээлсэн үү?

БҮЛЭГ.3 Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т заасан этгээд хяналтыг хэрэгжүүлж байгаа эсэх,
3.1. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан этгээд хяналтыг хэрэгжүүлж байгаа эсэх?
3.2. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан этгээд хяналтыг хэрэгжүүлж байгаа эсэх?
3.3. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт
Илрүүлсэн зөрчил.....

Дүгнэлт.....

Зөвлөмж.....

Холбогдох байгууллагын санал.....

Хавсралтууд.....

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АЗЗА	Авто зам, засвар арчлалт
БСУГ	Боловсрол, соёл, урлагийн газар
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ГИХГ	Гадаадын иргэний харьяатын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХГБХХ	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХМХА	Хилийн мэргэжлийн хяналтын алба
ЕА	Ерөнхий аудитор
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗГХЭГ	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газар
ИНХ	иргэдийн Нийтийн Хурал
ИТН	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МУ	Монгол Улс
НАГ	Нийцлийн аудитын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТХШС	Төрийн хяналт шалгалтын стандарт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЭДТТДҮТ	Тариалан эрхлэлтийг дэмжих техник туслалцааны дундын үйлчилгээний төв
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. 1. Аудит хийсэн үндэслэл

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтыг үндэслэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийж гүйцэтгэлээ.

1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалган дүгнэлт, зөвлөмж өгч, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд нийцлийн аудитын зорилт оршив. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд бүрэн хэрэгжүүлж байгаа эсэх,
2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд 6 дугаар зүйлд заасан мэдээллийг мэдээлж байгаа эсэх,
3. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т заасан этгээд хяналтыг хэрэгжүүлж байгаа эсэх,

Аудитад 2016 оны 3-р улирлын байдлаар Сэлэнгэ аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй, Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамрагдах орон нутгийн төсөвт 191, улсын төсвийн 48 байгууллага, орон нутгийн өмчит 10 аж ахуйн нэгж, төрийн өмчит 1 компани, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн 92 аж ахуйн нэгж, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээ үзүүлж буй 44 байгууллага зэрэг нийт 386 хуулийн этгээдийг хамруулав.

1.3 Аудитын арга зүй:

Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглахын зэрэгцээ Шилэн дансны тухай хуулийн 3-р зүйл, 8-р зүйлд заасан байгууллага, аж ахуйн нэгжийн ажлын тайлан, нэгдсэн болон өөрийн цахим хуудас, мэдээллийн самбарт байрлуулсан мэдээллийг дансны хуулга, анхан шатны баримт, журналтай тулгах, дүн шинжилгээ хийх, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, Санхүүгийн хяналт, аудитын албаны ажилтнууд, төсөвт байгууллагын дарга, нягтлан бодогчид болон холбогдох ажилтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, судлах, харьцуулалт хийх, тулган баталгаажуулах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр нотлох зүйл цуглуулан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа

“Төсвийн тухай хууль”, “Төрийн аудитын тухай хууль”, “Шилэн дансны тухай хууль”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “ТБОНӨХБАҮХА тухай хууль”, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”, Засгийн газрын 2016 оны 01-р сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам” болон холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Аудитыг Сэлэнгэ аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор С.Бат-Эрдэнэ, Б.Наранчимэг, аудитор Ц.Отгонбаяр,

Б.Эрдэнэзул, шинжээч С.Баасансүрэн, Ц.Уртнасан, Э.Эрдэнэзул, А.Дашбат, Ж.Цогт нар 2016 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэв.

1.5 Ерөнхий мэдээлэл

Сэлэнгэ аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамаарах төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд 231 байгууллага, аймаг, сумдын 18 ТЕЗ, ТӨХК-1 , улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа 92 аж ахуйн нэгж, байгууллага, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг үзүүлдэг 44 байгууллага зэрэг нийт 386 хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байна.

Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1

Хуулийн заалт	Байгууллагын төрөл	2016 оны 1-р улирал		2016 оны 3-р улирал	
		Аудитад хамрагдсан байгууллагын тоо	Мэдээлэл байршуулсан байгууллагын тоо	Аудитад хамрагдсан байгууллагын тоо	Мэдээлэл байршуулсан байгууллагын тоо
3.1.1 дэх заалт	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд	229	225	231	230
3.1.2 дэх заалт	Төрийн өмчит үйлдвэрийн газар	1	1	-	-
3.1.3 дах заалт	Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани	-	-	1	1
3Г-ын 29 тогтоолоор батлагдсан журмын дагуу	Төсвийн ерөнхийлөн захирагч	18	18	18	18
3.1.4 дэх заалт	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуй нэгж, байгууллага	-	-	92	-
3.1.5 дах заалт	Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч	-	-	44	9
Нийт дүн		**248**	**244**	**386**	**258**

Дээрх хүснэгтээс харахад өмнөх аудитад хамрагдсан байгууллагуудаас 3 нь хасагдаж, 141 байгууллага нэмэгдсэн байна. Үүнд: Хасагдсан байгууллагууд:

1. *Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 08-р сарын 31-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор татан буугдсан,*
2. *Тариалан эрхлэлтийг дэмжих техник туслалцааны дундын үйлчилгээний газар ОНӨААТҮГ, Ерөө сумын Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГ-ууд албан ёсоор татан буугдаагүй боловч үйл ажиллагаа явуулаагүй учир аудитад хамруулаагүй болно.*

Дараах байгууллагуудыг аудитад нэмж хамрууллаа. Үүнд:

1. Аймгийн Бүртгэл, статистикийн хэлтэс нь Засгийн газрын 2016 оны 07 сарын 27-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор бүтэц, нэр нь өөрчлөгдөж Улсын бүртгэлийн хэлтэс, Статистикийн хэлтэс гэсэн 2 байгууллага болсон байна,
2. Өмнөх аудитад хамрагдаагүй Нийгмийн даатгалын, Халамжийн, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангуудыг нэмж хамруулав,
3. Мандал суманд 2016 оны 01-р сарын 19-ний өдөр байгуулагдсан “Мишээл” хүүхдийн цэцэрлэг,
4. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ хийж гүйцэтгэсэн 92 аж ахуйн нэгж,
5. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 44 байгууллага, аж ахуйн нэгж зэрэг нийт 141 байгууллага,

АУДИТЫН ДҮН

Бүлэг 1

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд бүрэн хэрэгжүүлж байгаа эсэх

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж, ахуйн нэгжүүд шилэн дансны бие даасан цэс нээлгээгүй байна.

1.1 "Сэлэнгэ үржлийн цөм сүрэг" ОНӨААТҮГ нь Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн үйлчлэх хүрээний 3.1.1-т хамаарах, төрийн болон орон нутгийн өмчит 231 хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байгаагаас "Сэлэнгэ үржлийн цөм сүрэг" ОНӨААТҮГ нь шилэн дансны цахим хуудсанд 2016 оны эхний 3 улирлын байдлаар мэдээлвэл зохих мэдээллийг огт оруулаагүй бөгөөд бусад 230 хуулийн этгээд холбогдох мэдээллийг ямар нэгэн хэлбэрээр байршуулсан байна.

Хэрэглэгчийн хувийн мэдээллийг үнэн зөв байршуулаагүйгээс Автотээврийн үндэсний төвийн Сэлэнгэ салбар, Хорих 433-р ангийн цахим цэс Хушаат сумын шилэн дансны цахим хуудсанд байршсан байна.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулсан аймгийн ИТХ, ЗДТГ, 17 сумд, 30 хэлтэс агентлаг, 9 ОНӨААТҮГ, 1 ТӨХК зэрэг байгууллагуудын

мэдээллийг *Selenge.gov.mn* гэсэн Сэлэнгэ аймгийн цахим хуудсаар харж болохоор холболт хийгдэн, мэдээллийг давхар түгээж байна.

1.2. Шилэн дансны тухай хуулийн 3-р зүйлийн 3.1.2-д заасан компани Сэлэнгэ аймагт байхгүй байна.

1.3. "Сэлэнгэ АЗЗА" ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийн 3-р зүйлийн 3.1.2- д заасан хуулийн этгээдүүдээс Сэлэнгэ аймагт "Сэлэнгэ АЗЗА" ТӨХК үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд уг компани нь Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байгаагаас гадна нийтэд ил тод болгох мэдээллүүдийг цахимаар болон самбараар мэдээлсэн байна.

Зураг 1



1.4. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д заасан аж ахуйн нэгжүүд шилэн дансны цахим хуудсанд мэдээллээ байршуулаагүй байна.

2016 оны эхний 3 улирлын байдлаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 109 хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтэд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, аймаг хөгжүүлэх сан, аймаг, сумын ОНХС-аас нийт 92 аж ахуйн нэгжид 3,633.9 сая төгрөгийг олгосон боловч гүйцэтгэгч аж ахуй нэгжүүд шилэн дансны цахим хуудсанд цэс нээлгэж, холбогдох мэдээллийг байршуулаагүй байна.

1.5. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан байгууллагуудын 27,3 хувь нь хамрагдсан байна.

Сэлэнгэ аймагт төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль, тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэж буй 44 хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байна.

Эдгээрээс хувийн сургууль, цэцэрлэг, өрхийн эмнэлэг зэрэг 12 байгууллага шилэн дансны цахим цэсэнд өөрийн нэр, хаягаар бүртгэлтэй байна. Үүнд:

- *Эрдмийн чуулган сургууль*
- *Билиг ДБ сургууль*
- *Эрдмийн чуулган цэцэрлэг*
- *Азтай цэцэг цэцэрлэг*
- *Спейшл кидс цэцэрлэг*
- *"Хаданхуйн" өрхийн ЭМТ*
- *"Номтхан" өрхийн ЭМТ*
- *"Эмнэх" өрхийн ЭМТ*
- *"Зөвлөх" өрхийн ЭМТ*
- *“Баян баг” өрхийн ЭМТ*
- *“Ачит баг” өрхийн ЭМТ*
- *“Бату баг” өрхийн ЭМТ*

Мандал сум дахь 3 өрхийн эмнэлэгт /*Баян баг Өрхийн ЭМТ, Ачит баг өрхийн ЭМТ, Бату баг өрхийн ЭМТ*/ тус бүр цэс нээсэн боловч нэвтрэхэд алдаатай байгаа тул “Сэлэнгэ аймаг Мандал өрхийн эмнэлэг” гэсэн цэс давхар нээж мэдээлэл байршуулжээ.

Харин аймгийн Ахмадын хороо,Албан журмын даатгагчдын холбоо, Мандал сумын Ахмадын сувилал, сумдад хүүхэд харах үйлчилгээг үзүүлдэг 12 төв, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг 17 нэгж зэрэг нийт 32 байгууллага шилэн дансны цахим хуудсанд хамрагдаагүй байна. Үүнийг графикаар харуулбал:

График 1

Бүлэг 2

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд 6 дугаар зүйлд заасан мэдээллийг мэдээлж байгаа эсэх

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд хуулийн 6-р зүйлд заасан мэдээллийн 80.9 хувийг байршуулсан байна.

Оршил

3 дугаар улирлын байдлаар Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон орон нутгийн өмчит 249 хуулийн этгээд тогтсон хугацаанд 17-21 төрлийн, нийт 4525 удаагийн, 7 хоногийн дотор 4-12 төрлийн 5194 удаагийн мэдээллийг нийтэд ил тод болгохоос 7867 удаагийн мэдээллийг цахимаар болон самбараар мэдээлсэн байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2

Үзүүлэлт	Байгууллагын тоо	Тогтмол мэдээлэх мэдээллийн тоо		7 хоногийн дотор мэдээлэх мэдээллийн тоо		Нийт дүн		Мэдээлсэн дүн /%/
		Мэдээлвэл зохих	мэдээлсэн	Мэдээлвэл зохих	мэдээлсэн	Мэдээлвэл зохих	мэдээлсэн	Хувиар
Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллага	201	3681	2994	3125	2205	6806	5199	76.4
Улсын төсөвт байгууллага	48	844	726	2069	1942	2913	2668	91.6
Дүн	**249**	**4525**	**3720**	**5194**	**4147**	**9719**	**7867**	**80.9**

Үүнээс худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, өр үүсгэсэн шийдвэрийн талаарх мэдээлэл, худалдан авалтын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн зэргийг 10.7-46.9 хувьтай мэдээлсэн бол ОНХС-гийн төлөвлөгөө, гүйцэтгэл, хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт, авлага үүсгэсэн шийдвэр зэргийг бүрэн мэдээлсэн байна. */ Мэдээлэл байршуулсан талаарх судалгааг Хавсралт 3, 4-т дэлгэрэнгүйгээр харуулав/*

Шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээлэл оруулсан байдлаас харахад дараах нийтлэг зөрчил илэрч байна. Үүнд:

- ✓ *Зарим байгууллагууд журмын дагуу PDF, excel форматаар мэдээллийг хавсаргаагүй.*
- ✓ *Зарим байгууллагууд өөрт хамааралгүй мэдээллийн цонхонд тэмдэглэгээ хийж баталгаажуулахгүй байгаа нь мэдээлэл хэрэглэгчдийг төөрөгдүүлж байна.*
- ✓ *Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд зарим мэдээллийг оруулахдаа өгөгдсөн маягтыг зааврын дагуу иж бүрэн хөтлөхгүй байна. Тухайлбал таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг сар бүр өссөн дүнгээр бөглөөгүй байх гэх мэт.*

- ✓ *Ихэнх байгууллага мэдээллийг цаг хугацаанд нь оруулаагүй, хугацаа хэтрүүлсэн тэмдэглэгээтэй байна.*

2.1 3-р зүйлийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд 6-р зүйлийн 6.1-д заасан мэдээллийн 82.2 хувийг мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь 6.1-д заасан 17-21 төрлийн мэдээллийг тогтмол хугацаанд нийтэд ил тод болгохоор хуульчлагдсан юм.

Уг заалтад хамрагдах аймгийн хэмжээний нийт 249 хуулийн этгээдээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Халамжийн сан, Худалдан авах ажиллагааны алба, Мандал сумын 1-р сургууль, Орхонтуул сумын ЗДТГ, Рашаант тосгоны захирагчийн алба зэрэг 7 байгууллага, Алтанбулаг, Хушаат сумдын төсвийн ерөнхийлөн захирагчид зохих мэдээллийг бүрэн мэдээлсэн бол Сэлэнгэ үржлийн цөм сүрэг ОНӨААТҮГ мэдээлэл огт байршуулаагүй, бусад 239 байгууллага дутуу байршуулжээ.

Тухайлбал, зохих мэдээллийг хамгийн хангалтгүй байршуулсан буюу Статистикийн хэлтэс, Орхонтуул сумын 1-р сургууль, Бугант тосгоны захирагчийн алба, сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, соёлын төв зэрэг 7 төсөвт байгууллага, Сэлэнгэ барилга захиалагч, Сэлэнгэ Зүүнхараа зэрэг 2 ОНӨААТҮГ нь 18 төрлийн мэдээлэл байршуулахаас 10-16-г мэдээлээгүй, Хүдэр сумын ТЕЗ нь 21 төрлийн мэдээлэл байршуулахаас 18-г мэдээлээгүй байна.

Сэлэнгэ үржлийн цөм сүрэг ОНӨААТҮГ-ын холбогдох албан тушаалтнуудад удаа дараагийн аудитаар албан шаардлага, зөвлөмж хүргүүлж байгаа ч албан тушаалтнуудын хариуцлагагүй байдлаас шалтгаалан мэдээлэл байршуулаагүй бол бусад байгууллагын удирдлага, эрх бүхий албан тушаалтны хариуцлагагүй, хуулиа бүрэн судалж, ойлгоогүй зэргээс шалтгаалан мэдээллийг дутуу байршуулсаар байна.

3-р улирлын байдлаар улсын төсөвт 48 , орон нутгийн төсөвт 173 байгууллага, 18 ТЕЗ, 10 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар зэрэг нийт 249 хуулийн этгээд давхардсан тоогоор 4525 удаагийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулахаас 3720 удаагийн буюу 82.2 хувийн мэдээллийг байршуулжээ. Үүнийг хүснэгтээр нэгтгэн харуулбал:

Тогтсон хугацаанд мэдээлэл байршуулсан байдал

Хүснэгт 3

Хуулийн заалт	Хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд тогтмол хугацаанд мэдээлэл байршуулсан байдал	Мэдээлвэл зохих мэдээллийн тоо					Үүнээс цахимаар болон самбараар мэдээлсэн тоо					
		Улсын төсөвт	Орон нутгийн төсөвт	ТЕЗахирагч	ОНӨААТҮГ	Дүн	Улсын төсөвт	Орон нутгийн төсөвт	ТЕЗахирагч	ОНӨААТҮГ	Дүн	Хувиар /%/
	Байгууллагын тоо	**48**	**173**	**18**	**10**	**249**	**48**	**173**	**18**	**9**	**248**	**99.6**
	Мэдээллийн тоо. Үүнээс:	**844**	**3121**	**380**	**180**	**4525**	**726**	**2592**	**309**	**93**	**3720**	**82.2**
6.1.1	Тухайн жилийн төсөв	46	173	18	10	**247**	46	173	18	5	**242**	**98.0**
	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	43	172	18	10	**243**	6	7	12	1	**26**	**10.7**
	ОНХС-ийн төлөвлөгөө	0	0	19	0	**19**	0	0	19	0	**19**	**100.0**

6.1.2	Сар улирлын төсвийн гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор	470	1730	180	100	**2480**	462	1697	165	72	**2396**	**96.6**
6.1.3	Дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор	46	173	18	10	**247**	33	88	5	0	**126**	**51.0**
6.1.4	Жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04-р сарын 25-ны өдрийн дотор,	46	173	18	10	**247**	40	149	16	5	**210**	**85.0**
	хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор	46	173	18	10	**247**	35	141	10	4	**190**	**76.9**
6.1.5	ТЕЗ-ын төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор	48	172	18	10	**248**	39	136	15	5	**195**	**78.6**
	Аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор	48	165	18	10	**241**	24	74	7	0	**105**	**43.6**
6.1.6	Төсвийн хэтрэлт хэмнэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр	48	173	18	10	**249**	38	110	9	1	**158**	**63.5**
	Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл	0	0	19	0	**19**	0	0	19	0	**19**	**100.0**
	Тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт	0	0	18	0	**18**	0	0	14	0	**14**	**77.8**
	Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт	3	17	0	0	**20**	3	17	0	0	**20**	**100.0**

Үүнээс ОНХС-гийн төлөвлөгөө, гүйцэтгэл, хандив тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт зэрэг 3 төрлийн мэдээллийг бүрэн мэдээлсэн бол дараах 4 төрлийн мэдээллийг хамгийн бага буюу 10.7-63.5 хувьтай мэдээлжээ. Үүнд:

- *Хуулийн 6.1.1-д заасны дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 243 байгууллага жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор мэдээлэхээс 26 нь мэдээлж, 218 нь мэдээлээгүй,*
- *Хуулийн 6.1.5-д заасны дагуу аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг 241 байгууллага тухайн жилийн 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор мэдээлэхээс 105 нь мэдээлж, 136 нь мэдээлээгүй,*
- *Хуулийн 6.1.3-т заасны дагуу дараа жилийн төсвийн төслийг 247 байгууллага жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор мэдээлэхээс 126 нь мэдээлж, 121 нь мэдээлээгүй,*
- *Хуулийн 6.1.6-д заасны дагуу төсвийн хэтрэлт хэмнэлт, түүний шалтгааны тайлбарыг 249 байгууллага улирал бүр мэдээлэхээс 158 нь мэдээлж, 91 нь мэдээлээгүй байна.*

Харин дараах 6 төрлийн мэдээллийг 76.9-98.0 хувьтай байршуулжээ. Үүнд:

- *Хуулийн 6.1.4-т заасны дагуу хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор 247 байгууллага мэдээлэхээс 190 нь мэдээлж, 57 нь мэдээлээгүй,*

- *Хуулийн 6.1.6-д заасны дагуу тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтыг 18 ТЕЗ мэдээлэхээс 14 нь мэдээлж, Баруунбүрэн, Орхонтуул, Сүхбаатар, Хүдэр сумдын ТЕЗ мэдээлээгүй,*
- *Хуулийн 6.1.5-д заасны дагуу ТЕЗ-ийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор 248 байгууллага мэдээлэхээс 195 нь мэдээлж 53 нь мэдээлээгүй,*
- *Хуулийн 6.1.4-т заасны дагуу жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04-р сарын 25-ны өдрийн дотор 247 байгууллага мэдээлэхээс 210 нь мэдээлж, 37 нь мэдээлээгүй,*
- *Хуулийн 6.1.2-т заасны дагуу сар, улирлын төсвийн гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор 248 байгууллага 2480 удаа мэдээлэхээс 2396 удаа мэдээлж, 17 байгууллага 1-10 сарын мэдээллийг дутуу болон огт оруулаагүй,*
- *Хуулийн 6.1.1-д заасны дагуу тухайн жилийн төсвийг жил бүрийн 01-р сарын 10-ны дотор 247 байгууллага мэдээлэхээс 242 нь мэдээлж, Сэлэнгэ барилга захиалагч, Хүдэр ойн анги, Сэлэнгэ үржлийн цөм сүрэг, Туулын хишиг, Сэлэнгэ үйлчилгээ зэрэг 5 ОНӨААТҮГ мэдээлээгүй байна.*

2.2. 3-р зүйлийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд 6-р зүйлийн 6.4-д заасан мэдээллийг 79.8 хувьтай мэдээлсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-т заасан 4-12 төрлийн мэдээллийг долоо хоногийн дотор нийтэд ил тод болгохоор хуульчлагдсан билээ.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэгч, аудитад хамрагдсан байгууллагууд 3-р улирлын байдлаар нийт 5194 удаагийн мэдээллийг нийтэд ил тод болгохоос 4147 удаагийн буюу 79.8 хувийг цахим хуудсаар болон самбараар мэдээлсэн байна. Үүнийг хүснэгтээр нэгтгэн харуулбал:

Тухайн мэдээлэл гарснаас хойш
7 хоногийн хугацаанд мэдээлэл байршуулсан байдал

Хүснэгт 4

Хуулийн заалт	3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 3-р улирлын байдлаар 7 хоногийн дотор нийтэд ил тод болгох мэдээлэл	Мэдээлвэл зохих мэдээллийн тоо					Үүнээс цахимаар болон самбараар мэдээлсэн тоо					
		Улсын төсвөт	Орон нутгийн төсвөт	ТЕЗахирагч	ОНӨААТҮГ	**Дүн**	Улсын төсвөт	Орон нутгийн төсвөт	ТЕЗахирагч	ОНӨААТҮГ	**Дүн**	**Хувиар /%/**
3.1.1, 3.1.2	**Байгууллагын тоо**	**48**	**173**	**18**	**10**	**249**	**48**	**173**	**18**	**9**	**248**	**99.6**
	Мэдээллийн тоо. Үүнээс:	**2069**	**2166**	**491**	**468**	**5194**	**1942**	**1481**	**326**	**398**	**4147**	**79.8**
6.4.1	Тухайн жилийн төсвөт орсон нэмэлт, өөрчлөлт	48	173	18	10	**249**	41	141	12	8	**202**	**81.1**
6.4.2	Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт	37	95	18	10	**160**	22	64	13	9	**108**	**67.5**
6.4.3	Тендер, худалдан авалттай холбоотой мэдээлэл	48	169	233	0	**450**	33	146	113	0	**292**	**64.9**

6.4.4	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	154	189	91	26	**460**	140	103	84	12	**339**	**73.7**
6.4.5	Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	1250	380	0	136	**1766**	1230	281	0	131	**1642**	**93.0**
	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	304	18	0	173	**495**	293	8	0	159	**460**	**92.9**
6.4.6	Худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	34	133	19	10	**196**	21	49	18	4	**92**	**46.9**
6.4.7	Байгууллагуудын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	43	173	0	10	**226**	34	137	0	9	**180**	**79.6**
6.4.8	Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл	101	663	93	81	**938**	80	379	67	57	**583**	**62.2**
	Өр үүсгэсэн шийдвэрийн талаарх мэдээлэл	2	0	0	2	**4**	0	0	0	1	**1**	**25.0**
	Авлага үүсгэсэн шийдвэрийн талаарх мэдээлэл	0	0	1		**1**		0	1		**1**	**100.0**
6.4.9	Хууль тогтоомжинд заасан бусад мэдээлэл	48	173	18	10	**249**	48	173	18	8	**247**	**99.2**

Үүнээс авлага үүсгэсэн шийдвэрийн талаарх мэдээллийг бүрэн мэдээлсэн бол бусад 11 төрлийн мэдээллийн 2,0-80,0 хүртэлх хувийг дутуу мэдээлсэн байна. Тухайлбал, дараах 2 мэдээллийг хамгийн бага буюу 25.0-46.9 хувьтай байршуулсан байна. Үүнд:

- *3 байгууллага нийт 4 удаагийн 27.1 сая төгрөгийн өр үүсгэсэн шийдвэрийг мэдээлэхээс Мандал сум дахь Хорих 433-р анги, Туулын хишиг ОНӨААТҮГ нь 3 удаагийн 21.1 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй,*
- *3-р улирлын байдлаар нийт 196 байгууллагад дотоод аудит, хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт гэх мэт 1-4 удаагийн хяналт шалгалт хийгдсэн байна. Холбогдох албан тушаалтнууд хяналт шалгалтын тайлан, дүнг 7 хоногийн дотор нийтэд мэдээлэх атал 92 нь мэдээлж, 104 нь мэдээлээгүй байна.*

Харин дараах 3 төрлийн мэдээллийг хамгийн өндөр хувьтай буюу 92.9-99.2 хувьтай мэдээлжээ. Үүнд:

- *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 1766 удаагийн мөнгөн гүйлгээг мэдээлэхээс дараах байгууллагуудаас бусад 1608 гүйлгээг мэдээлсэн байна. Тухайлбал,: ХМХА, БСУГ, НХҮХ, МХГ, ЭМГ, Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтэс зэрэг 6 төсөвт байгууллага 20 удаагийн 192.1 сая төгрөгийн, Сэлэнгэ Зүүнхараа, Сэлэнгэ үйлчилгээ, Сэлэнгэ- Энерго, Цант Орхон, Гавшгай-Ус зэрэг 5 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 14 удаагийн 307.4 сая төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй бол Баянгол, Ерөө, Зүүнбүрэн, Орхон, Цагааннуур сумдын төсөвт байгууллагууд уг мэдээллийг огт оруулаагүй байсан бөгөөд Мандал, Сүхбаатар, Хүдэр сумын төсөвт байгууллагууд мэдээллийг дутуу оруулсан байна.*

- *Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 495 удаагийн мөнгөн гүйлгээг мэдээлэхээс дараах байгууллагуудаас 460 гүйлгээг мэдээлсэн байна. Тухайлбал, БСУГ, МХГ, ЭМГ, Хорих 433-р анги зэрэг 4 байгууллага 11 удаагийн 265.5 сая төгрөгийн, Хүдэр ойн анги, Туулын хишиг, Сэлэнгэ үйлчилгээ, Сэлэнгэ зүүнхараа, Сэлэнгэ -Энерго зэрэг 5 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 14 удаагийн 173.1 сая төгрөгийн, Баянгол, Сант, Цагааннуур сумдын ЗДТГ, Жавхлант сумын сургууль, Мандал сумын Мөнгөн хараа чуулга зэрэг 5 байгууллага 12 удаагийн 217.5 сая төгрөгийн орлогын гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.*
- *Хууль тогтоомжид заасан бусад мэдээллийг 249 байгууллага мэдээлэхээс Хүдэр ойн анги, Сэлэнгэ үржлийн цөм сүрэг ОНӨАТҮГ-аас бусад байгууллагууд мэдээлсэн байна.*

Бусад 6 төрлийн, дараах мэдээллийг 62.5-81.1 хувьтай мэдээлсэн байна. Үүнд:

- *3-р улирлын байдлаар төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 938 удаагийн шийдвэр гарснаас дараах байгууллагуудаас бусад байгууллагууд 583 мэдээллийг мэдээлсэн байна. Тухайлбал улсын төсөвт УЦУОША, ГИХГ-ын Хойд бүс дэх газар, ОБГ, НХҮХ, Шаамар сумын МСҮТ, МХГ, ЭМНДХ зэрэг 7 байгууллага 21 удаагийн 43.9 төгрөгийн, Сэлэнгэ үйлчилгээ, Сэлэнгэ Зүүнхараа, Сэлэнгэ-Энерго, Урсгал-Ус зэрэг 4 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 24 удаагийн 28.7 сая төгрөгийн, аймгийн ТЕЗ, Мандал, Сайхан, Цагааннуур сумдын ТЕЗ нар болон Сэлэнгийн долгио чуулга, ГХБХБГ, сумдын төсөвт байгууллагууд төсөв, өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой 310 удаагийн 1149.5 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна.*
- *Улс, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр болон жилийн батлагдсан төсвийн хүрээнд бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер, худалдан авалттай холбоотой 450 удаагийн мэдээллийг нийтэд ил тод болгохоос 292-г мэдээлжээ. Улсын төсөвт Хорих 433-р анги, ЭМНДХ, Сайхан сумын сум дундын нэгдсэн эмнэлэг зэрэг 3 байгууллага 12 удаагийн тендер шалгаруулсан мэдээллийг мэдээлээгүй бол аймгийн ТЕЗ тендерт шалгараагүй 50 удаагийн, Алтанбулаг, Баянгол, Ерөө, Орхон, сант, Сайхан, Хүдэр, Хушаат, Түшиг, Цагааннуур сумдын ТЕЗ-д 93 удаагийн тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн мэдээллийг мэдээлээгүй байна.*
- *Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг 160 байгууллага нийтэд ил тод болгохоос 108 нь мэдээлж, 52 нь мэдээлээгүй байна.*
- *Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн талаарх 460 удаагийн мэдээллийг нийтэд ил тод болгохоос 339-г мэдээлж, 121-г мэдээлээгүй байна. Тухайлбал, улсын төсөвт ХМХА, Гаалийн газар, ГИХГ-ын Хойд бүс дэх газар, Цагдаагийн газар, Хорих 433-р анги зэрэг 5 байгууллага 14 удаагийн 342.4 сая төгрөгийн, Сэлэнгэ үйлчилгээ, Сэлэнгэ Зүүнхараа, Сэлэнгэ- Энерго, Цант -Орхон, Гавшгай- Ус зэрэг 5 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 14 удаагийн 307.4 сая төгрөгийн, аймгийн ТЕЗ-ийн харьяа БОАЖГ, ГХБХБГ, Сайхан, Хүдэр, Орхонтуул, Мандал, Зүүнбүрэн, Алтанбулаг, Цагааннуур, Шаамар, Орхон, Баянгол, Ерөө зэрэг 11 сумын ТЕЗ, зарим төсөвт байгууллагууд 93 удаагийн 1199.0*

сая төгрөгийн худалдан авалтын талаарх мэдээллийг дутуу болон огт мэдээлээгүй байна.

- *Батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг нийт 226 байгууллага мэдээлэхээс 180 нь мэдээлж, 46 нь мэдээлээгүй байна.*
- *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдээллийг 249 байгууллага мэдээлэхээс 202 нь мэдээлж, 47 нь мэдээлээгүй байна.*

2.3. Тус заалт нь Сэлэнгэ аймагт хамааралгүй болно.

2.4. 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан хуулийн этгээд нь 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийн 33.3 хувийг мэдээлсэн байна.

Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж буй “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК -д хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.1, 6.8.3-д заасан мэдээллүүд хамааралгүй бөгөөд 6.8.2-т заасан 3 төрлийн мэдээллээс худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан гэсэн 2 төрлийн мэдээллийг байршуулаагүй байна.

Зураг 2



“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК нь хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан 115.0 сая төгрөгийн тээвэр, шатахууны зардалд нээлттэй тендер зохион байгуулсан байна.

Зураг 3

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2016 оны 02-р сарын 22
Тендер шалгаруулалтын нэр: Шатахуун нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах
Тендер шалгаруулалтын дугаар: СЭ АЗЗА 01/2016
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ХУГАЦАА: 2016.03.22

"СЭЛЭНГЭ АЗЗА"ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос 2016 оны авто замын засвар, үйлдвэрлэлийн ажилд шаардагдах ШАТАХУУН нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерт оролцохыг урьж байна.

Тендерийн баримт бичгийг худалдан авах хүсэлтээ албан бичгээр ирүүлж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50000 [тавин мянган] төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн [45] хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийг **2016 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 11 цагаас өмнө** доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2016 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 11цаг 30 минутад** нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Материал зарах ба хүлээн авах хаяг :
Сэлэнгэ аймаг Сүхбаатар сум 4-р баг 5-р хэсэг
Утас : 99789392, Факс : 70363889/а/

ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу нээлттэй тендерийг зохион байгуулан, тендерт оролцогчдыг 3 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд бүртгэж дууссан байна.

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн №37 тоот албан бичгийг үндэслэн тендерт шаардлага ханган шалгарсан “НИК” ХХК-тай 2016 оны 05 дугаар сарын 06-ны өдөр

XX/03 дугаар “Шатахуун шатах тослох материал худалдах, худалдан авах” гэрээг байгуулсан байна.

Шилэн дансны 4-р сарын мэдээнд “НИК” ХХК-г нээлттэй тендерт шалгарсан тухай мэдээлсэн байна.

2.5. Хуулийн 3.1.4-д заасан байгууллагууд шилэн дансанд шинээр цэс нээлгээгүйгээс мэдээллийг огт байршуулаагүй бол 3.1.5-д заасан байгууллагууд 6-р зүйлийн 6.9-д заасан мэдээллийн 55,3 хувийг байршуулсан байна.

Аймгийн хэмжээд хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээний зориулалтаар 92 аж ахуйн нэгжийн 109 ажил, үйлчилгээнд аймаг хөгжүүлэх сан, улс, орон нутгийн хөрөнгө оруулалт, аймаг, сумын ОНХС-аас нийт 3,633.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аж ахуйн нэгжүүдэд олгосон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн мэдээллийг холбогдох төсвийн захирагч, албан тушаалтнуудын зүгээс мэдээлж байгаа боловч аж ахуйн нэгжүүд нь нь шилэн дансны цахим хуудсанд огт цэс нээлгээгүйгээс мэдээлээгүй байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчид олгосон санхүүжилтийг захиалагчийн зүгээс тухай бүр шилэн дансанд мэдээлэхээр хуульчлагдсан атал гүйцэтгэгч аж ахуй нэгжүүд давхар мэдээлэх үүрэг хүлээж буй нь ажлын давхардал үүсгэж буй эсэх талаар санал боловсруулж холбогдох байгууллагуудад уламжилж шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Тайлант хугацаанд гүйцэтгэгчид олгосон 3,633.9 сая төгрөгийн санхүүжилтээс 496.5 сая төгрөг нь урьд оны үлдэгдэл байгаа нь нийт санхүүжилтийн 14,0 хувийг эзэлж байна.

График 2

Хуулийн 3.1.5-д заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.9-д заасан мэдээллийн 55.3 хувийг мэдээлсэн байна.

2016 оны 3-р улирлын байдлаар хуулийн 3.1.5-д хамаарах 44 хуулийн этгээд улс, орон нутгийн төсвөөс нийт 768.4 сая төгрөгийн санхүүжилт авснаас 44,7 хувийг буюу 343,7 сая төгрөгийн санхүүжилтийн гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй байна.

Шилэн дансанд мэдээллээ байршуулаагүй байгууллагуудын санхүүжилтийн гүйлгээг дэлгэрэнгүйгээр харуулбал:

Хүснэгт 5

№	Байгууллагын нэр	Санхүүжилт олгосон байгууллагын нэр	Нийт төсөв /сая.төг/	Санхүүжилт өссөн дүнгээр /сая.төг/	Санхүүжилтийн хувь
1	Аймгийн ахмадын хороо	АЗДТГ	42.2	28.2	66.8
2	Мандал сумын ахмадын сувилал	АЗДТГ	50.5	36.2	71.6
3	Албан журмын даатгагчдын холбоо	АЗДТГ	56.3	37.6	66.8
4	Сумдын хүүхэд харах үйлчилгээний 12 байгууллага	ХГБХХэлтэс	375.7	86.5	23.0
5	Сумдын мал эмнэлэгийн үйлчилгээний 17 байгууллага	ХХААГазар	219.3	78.2	35.6
6	Сүхбаатар сумын Эрдмийн чуулган сургууль	Орон нутгийн төсөв	34.9	27.1	78.0
7	Сүхбаатар сумын Эрдмийн чуулган цэцэрлэг	Орон нутгийн төсөв	20.4	17.0	83.0
8	Сайхан сумын “Азтай цэцэг” цэцэрлэг	Орон нутгийн төсөв	43.9	32.9	75.0
Нийт дүн			**843.2**	**343.7**	**40,8**

Бүлэг 3

Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т заасан этгээд хяналтыг хэрэгжүүлж байгаа эсэх

Хөндлөнгийн болон дотоод хяналтаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлээгүйгээс зөрчил бүрэн арилахгүй байна.

3.1. Аймгийн ИТХ- ын зүгээс холбогдох байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийгдэхгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 8.1-т “*Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурал, иргэдийн Нийтийн хурал... хэрэгжүүлнэ*” гэж заасан боловч Шилэн дансны тухай хууль хэрэгжиж эхлээд даруй 2 жил шахам хугацаа өнгөрсөн байхад аймгийн ИТХ “ *Бүх шатны ИТХ яаж, ямар байдлаар хяналт тавих нь тодорхой бус, хяналт тавих журам гараагүй, Сангийн яаманд хандсан боловч хариу ирүүлээгүй”* гэдэг шалтгаанаар бие дааж хөндлөнгийн хяналт хийгээгүй байна.

Аймгийн ИТХ-ын хөндлөнгийн хяналт хийх журмыг Сангийн яам болон бусад ямар нэгэн байгууллага, албан тушаалтнаас боловсруулан хүргүүлэх бус тус байгууллага өөрийн бүрэн эрхийн хүрээнд хөндлөнгийн хяналт хийхээр хуульчлагдсан юм.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 12-р сарын хуралдаанаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавьж буй хяналтын талаар аймгийн

Санхүүгийн хяналт, аудитын албаны мэдээллийг сонсохоор төлөвлөсөн гэж байгаа ч биелүүлээгүй зэргээс үндэслэн Сэлэнгэ аймгийн ИТХ нь Шилэн дансны тухай хуулийн 8-р зүйлийн 8.1-д заасан хөндлөнгийн хяналт тавих эрх, үүргээ хэрэгжүүлээгүй байна гэж дүгнэж байна.

Сумдын хувьд Алтанбулаг, Баруунбүрэн, Баянгол, Зүүнбүрэн, Орхон, Орхонтуул, Сант, Сайхан, Түшиг, Хүдэр, Шаамар зэрэг 11 сумдын ИТХ нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд ямар нэгэн байдлаар хяналт хийж, түүний мөрөөр холбогдох арга хэмжээ авах тогтоол, шийдвэр гаргасан бол Жавхлант, Мандал, Ерөө, Сүхбаатар, Хушаат, Цагааннуур сумдын ИТХ-аас тайлант хугацаанд тухайн нутаг дэвсгэр дэх Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хийгээгүй байна. Үүнийг графикаар харьцуулан харуулбал:

График 3



Урьд оны мөн үед 14 сумын ИТХ-аас хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн дүн мэдээтэй байсан бол 2016 оны эхний 3 улирлын байдлаар уг үзүүлэлт 11 болж буурсан нь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд уг хуулийн үйлчлэлд ач холбогдол өгч, төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах талаар хангалтгүй ажиллаж байгааг харуулж байна. Графикаар харуулбал:

График 4



Шилэн дансны тухай хууль хэрэгжиж эхэлснээр төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж хөрөнгө, мөнгөний зарцуулалтад иргэд, олон нийтийн зүгээс хяналт тавих боломжтой болсноос гадна багийн ИНХ-аас хөндлөнгийн хяналт хийхээр хуульчлагдсан боловч хэрэгжүүлээгүй байна.

3.2 Аймгийн ТЕЗ-ийн зүгээс шилэн дансны үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналтаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэхгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 8-р зүйлийн 8.2 дахь "*Төрийн болон, орон нутгийн өмчит хуулийн этгээд, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ*" гэсэн заалтын дагуу аймгийн ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2016 оны 1, 3-р улиралд тус бүр 1 удаа, нийт 2 удаа төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналт хийж, дүгнэлт гаргажээ.

Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2016 оны 01 сарын 01-нээс 10 сарын 01 хүртэлх хугацааг хамруулан хийсэн дотоод хяналтад нийт 212 байгууллагыг хамруулан, шилэн дансны мэдээлэл байршуулалт 76.9 хувьтай байна гэсэн дүгнэлт хийсэн байна. Уг хяналтаар мэдээлэл дутуу байршуулсан 49 байгууллага, байршуулаагүй 2 байгууллагын холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж өгч, 2016 оны 10 сарын 31-ний дотор шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулж дуусгахыг анхааруулжээ.

Хэдийгээр аймгийн ТЕЗ-ийн зүгээс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд холбогдох хяналт шалгалтыг хийж, зөрчил арилгах зөвлөмж өгч байгаа боловч зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэх ажил хийгдэхгүй байгаагаас шилэн дансанд мэдээлэл дутуу байршуулах зөрчил бүрэн арилахгүй байна.

3.3. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 62.1 хувьтай байна.

2015 оны 11-р сард хийж гүйцэтгэсэн "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт" сэдэвт аудитаар аймгийн ТЕЗ-д 5, сумдын ТЕЗ, төсөвт байгууллагуудын төсвийн захирагч нарт 2 зэрэг нийт 7 зөвлөмж хүргүүлснийг 63.0 хувьтай хэрэгжүүлсэн бол 2016 оны 1-р улиралд хийж гүйцэтгэсэн "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт" сэдэвт нийцлийн аудитаар аймгийн ТЕЗ-д 6, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт 2 зэрэг нийт 8 зөвлөмж хүргүүлснийг 62.1 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлсэн байна.

Өмнө хийгдсэн аудитуудын зөвлөмжийн хэрэгжилтийг графикаар харьцуулан харуулбал:

График 5



2016 оны 1-р улирлын байдлаар хийгдсэн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт 6/

д/д	Зөвлөмж өгөгдсөн албан тушаалтан	Зөвлөмжийн утга	Зөвлөмжийн хэрэгжилтийг хангасан байдал	Хэрэгжилтийн хувь
1.	Аймгийн ТЕЗ С.Бүрэнбатад	Цахим санд мэдээллээ оруулаагүй болон цэс нээгээгүй ОНӨААТҮГазруудын цэсийг цахим санд нээлгэн, холбогдох мэдээллийг бүрэн мэдээлүүлэх арга хэмжээ авах	“Хүдэр сумын Ойн анги” шилэн дансны цахим хуудсанд цэс нээлгэж мэдээллээ байршуулсан байна. Харин “Сэлэнгэ үржлийн цөм сүрэг” ОНӨААТҮГ нь шилэн дансны цахим хуудсанд цэс нээлгэсэн ч мэдээлэл байршуулаагүй байна.	50,0
		Шилэн дансны цахим санд оруулбал зохих мэдээллийг бүрэн мэдээлж байх, дутуу оруулсан мэдээллүүдийг нөхөж оруулах	ТЕЗ болон түүний харьяа байгууллагууд нь шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллийг 76.4хувьтайгаар мэдээлсэн байна.	76.4
		Шилэн дансны нэгдсэн цахим системд давхар үүсгэсэн, ашиглагдахгүй байгаа цэсүүдийг цэгцлэх.	1-р улиралд хийгдсэн шилэн дансны аудитаар Хэрх, Түнхэл, Номгон, Бугант, Дулаанхаан тосгодууд, Алтанбулаг, Орхон сумдын хот тохижуулах газар, Түшиг сумын эмнэлэг давхар цэс нээлгэсэн зэрэг шалтгаанаар нийт 8 цэс илүү нээгдсэнийг 3-р улирлын байдлаар цэгцлээгүй байна.	Хэрэг-жээгүй
		ТЕЗ-ийн зүгээс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавигдаж буй хяналт, шалгалтын үр нөлөөг сайжруулах, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох	Шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлээгүй Мандал, Жавхлант сумын Засаг дарга болон байгууллагуудын нягтлан бодогч нарт сахилгын хариуцлага тооцож, хариуцлагатай ажиллахыг үүрэг болгосон байна.	100,0
		ТЕЗ-ийн харьяаны байгууллага, албан тушаалтны ажлын үр дүн, гэрээг дүгнэхдээ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг авч үзэж байх	Аймгийн ТЕЗ болон сумдын ТЕЗ нараас харьяаны байгууллага, албан тушаалтны ажлын үр дүн, гэрээг дүгнэхдээ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг авч үзсэн талаар мэдээлээгүй байна.	Хэрэг-жээгүй
		Шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээлэл байршуулах үүрэг бүхий албан тушаалтнуудад нэгдсэн ойлголт өгч, гарын авлага, зааврааар хангах	Санхүүгийн хяналт дотоод аудитын алба нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулах үүрэг бүхий албан тушаалтнуудад 2 удаа сургалт зохион байгуулсан ба аймгийн албан ёсны сайтад 2 удаа мэдээлэл, 1 удаа зөвлөмж байршуулсан байна.	100,0
2.	Төрийн болон орон нутгийн	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хуулийн хугацаанд нь үнэн зөв мэдээлж, дутуу мэдээлсэн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим системд 2016 оны 06-р сарын 01-ний өдрийн дотор нөхөн	18 ТЕЗ, 7 ОНӨААТҮГ-аас Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нөхөж мэдээлсэн ба хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	80,9

	өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт	байршуулж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах		
		Шилэн дансны нэгдсэн цахим системд байршуулах мэдээллийн хавсралтыг үнэн зөв, баталгаажсан, журманд заасан форматаар, файлын нэрийг агуулгад тохирсноор оруулах, түүнд хяналт тавих	нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд маягтийн дагуу мэдээллийг ихэнх байгууллагууд PDF, excel файлаар оруулж байна.	90,0
Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь /дунджаар/				**62.1**

АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар нийт **5,850.3** сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

1. **5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалттай холбоотой мэдээллийг оруулаагүй нийт 1,848.7 сая төгрөгийн**. Үүнд:
   - *Улсын төсвийн 5 байгууллага, 14 худалдан авалтын 342.4 сая төгрөгийн,*
   - *14 сумын орон нутгийн төсвийн болон ТЗШ-ийн 50 байгууллага 1,198.9 сая төгрөгийн,*
   - *5 ОНӨААТҮГ ,14 удаагийн 307.4 сая төгрөгийн.*
2. **Цалингийн зардлаас бусад 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээг мэдээлээгүй 1,751.5 сая төгрөгийн. Үүнд:**
   - *Улсын төсвийн 5 байгууллага, 20 удаагийн 192.1 сая төгрөгийн,*
   - *14 сумын, орон нутгийн төсвийн болон ТЗШ-ийн 50 байгууллага 110 удаагийн 1,511.2 сая төгрөгийн,*
   - *4 ОНӨААТҮГ, 5 удаагийн 48.2 сая төгрөгийн зарлагын гүйлгээг*,

3. **5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээг мэдээлээгүй 643.0 сая төгрөгийн. Үүнд:**
   - *Улсын төсвийн 4 байгууллага, 11 удаагийн 265.5 сая төгрөгийн,*
   - *Орон нутгийн төсвийн болон ТЗШ-ийн 7 байгууллага 10 удаагийн 204.4 сая төгрөгийн,*
   - *5 ОНӨААТҮГ, 14 удаагийн 173.1 сая төгрөгийн орлогын гүйлгээг,*
4. **Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн талаар мэдээлээгүй 1,222.1 сая төгрөгийн. Үүнд:**
   - *Улсын төсвийн 7 байгууллага, 21 удаагийн 43.9 сая төгрөгийн,*
   - *Орон нутгийн төсвийн болон ТЗШ-ийн 60 байгууллага, 310 удаагийн 1,149.5 сая төгрөгийн,*
   - *4 ОНӨААТҮГ, 24 удаагийн, 28.7 сая төгрөгийн орлогын гүйлгээг,*
5. **Өр төлбөр, авлага дутуу мэдээлсэн 41.3 сая төгрөгийн. Үүнд:**
   - *Улсын төсвийн 1 байгууллага 1.1 сая төгрөгийн өглөг, 20.2 сая төгрөгийн авлага,*
   - *1 ОНӨААТҮГ 20.0 сая төгрөгийн өглөгийг тус тус мэдээлээгүй.*

6. Сэлэнгэ аймагт төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль, тогтоомж, гэрээний үндсэн дээр хийж гүйцэтгэгч 35 байгууллага шилэн

дансны нэгдсэн цахим хуудсанд цэс нээлгээгүйгээс **343.7** сая төгрөгийн санхүүжилтийг мэдээлээгүй,

7. Тухайн жилийн төсвийг 01-р сарын 10-ны өдрийн дотор мэдээлэхээс 5 ОНӨААТҮГ мэдээлээгүй,

8. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жил бүрийн 01-р сарын 10-ны өдрийн дотор мэдээлэхээс улсын төсвийн 37, орон нутгийн болон ТЗШ-ийн 171 байгууллага, 9 ОНӨААТҮГ зэрэг нийт 217 хуулийн этгээд мэдээлээгүй,
9. Дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор мэдээлэхээс улсын төсвийн 13, орон нутгийн болон ТЗШ-ийн 98 байгууллага, 10 ОНӨААТҮГ зэрэг нийт 121 хуулийн этгээд мэдээлээгүй,
10. 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор мэдээлэхээс улсын төсвийн 6, орон нутгийн болон ТЗШ-ийн 25 байгууллага, 5 ОНӨААТҮГ зэрэг нийт 36 хуулийн этгээд мэдээлээгүй,
11. 2016 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор мэдээлэхээс улсын төсвийн 11, орон нутгийн болон ТЗШ-ийн 40 байгууллага, 6 ОНӨААТҮГ зэрэг нийт 57 хуулийн этгээд мэдээлээгүй,
12. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор мэдээлэхээс улсын төсвийн 9, орон нутгийн болон ТЗШ-ийн 39 байгууллага, 5 ОНӨААТҮГ зэрэг нийт 53 хуулийн этгээд мэдээлээгүй,
13. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор мэдээлэхээс улсын төсвийн 19, орон нутгийн болон ТЗШ-ийн 102 байгууллага, 10 ОНӨААТҮГ зэрэг нийт 131 хуулийн этгээд мэдээлээгүй,
14. Төсвийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарыг улирал бүр мэдээлэхээс улсын төсвийн 9, орон нутгийн болон ТЗШ-ийн 72 байгууллага, 9 ОНӨААТҮГ зэрэг нийт 90 хуулийн этгээд мэдээлээгүй,
15. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг улсын төсвийн 6 , орон нутгийн болон ТЗШ-ийн 38 байгууллага, 2 ОНӨААТҮГ зэрэг нийт 46 хуулийн этгээд мэдээлээгүй,
16. Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг улсын төсвийн 15, орон нутгийн болон ТЗШ-ийн 36 байгууллага, 1 ОНӨААТҮГ зэрэг нийт 52 хуулийн этгээд мэдээлээгүй,
17. Худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнгийн талаарх мэдээллийг улсын төсвийн 13, орон нутгийн болон ТЗШ-ийн 85 байгууллага, 6 ОНӨААТҮГ зэрэг нийт 104 хуулийн этгээд мэдээлээгүй,
18. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг улсын төсвийн 9, орон нутгийн болон ТЗШ-ийн 36 байгууллага, 1 ОНӨААТҮГ зэрэг нийт 46 хуулийн этгээд мэдээлээгүй,
19. "Сэлэнгэ үржлийн цөм сүрэг" ОНӨААТҮГ нь шилэн дансны цахим хуусанд 2016 оны эхний 3 улирлын байдлаар мэдээлвэл зохих мэдээллийг огт оруулаагүй байна.
20. 12 сумын төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлтийг мэдээлээгүй зэрэг зөрчил илэрлээ.

АУДИТЫН ДҮГНЭЛТ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. *Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн 99,6 хувь нь нийт мэдээлвэл зохих мэдээллийн 80,9 хувийг мэдээлсэн байна./ Сэлэнгэ үржлийн цөм сүрэг" ОНӨААТҮГ- аас бусад /*
2. *Аймгийн ТЕЗ-ийн харьяа 201 байгууллага шилэн дансанд мэдээлвэл зохих мэдээллийн 76,4 хувийг байршуулсан байна.*
3. *Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж буй улсын төсөвт 48 байгууллага шилэн дансны мэдээллийн 91,6 хувийг мэдээлсэн байна.*
4. *Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүд шилэн дансны бие даасан цэс нээлгээгүй, холбогдох мэдээллийг байршуулаагүй байна.*
5. *Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль, тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэж буй хуулийн этгээдийн 27,7 хувь нь шилэн дансанд цэс нээлгээгүй бөгөөд мэдээлвэл зохих мэдээллийн 44,7 хувийг мэдээлээгүй байна.*
6. *Аймгийн ИТХ- ын зүгээс холбогдох байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийгдэхгүй байна.*
7. *Аймгийн ТЕЗ-ийн зүгээс шилэн дансны үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналтаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэхгүй байна.*
8. *Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 62.1 хувьтай байна.*

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн ИТХ-ын дарга Г.Бямбаад

1. *Шилэн дансны тухай хуулийн 8-р зүйлийн 8.1 дэх заалтын дагуу аймгийн ИТХ- ын зүгээс холбогдох байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийж, үнэлэлт дүгнэлт өгөх.*

Аймгийн Засаг дарга Ш.Оргилд:

1. *Шилэн дансны цахим санд цэс үүсгэсэн боловч мэдээллээ огт байршуулаагүй Сэлэнгэ үржлийн цөм сүрэг ОНӨААТҮГ-ын мэдээллийг шилэн дансанд байршуулах талаар холбогдох арга хэмжээ авах.*
2. *Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа хуулийн этгээдүүдийн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим санд бүрэн байршуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах, мэдээллээ бүрэн байршуулаагүй албан тушаалтнуудад хуулийн дагуу хариуцлага тооцох.*
3. *Шилэн дансны нэгдсэн цахим системд давхар үүсгэсэн, ашиглагдахгүй байгаа цэсүүдийг цэгцлэх.*

4. *Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль, тогтоомж, гэрээний үндсэн дээр хийж гүйцэтгэж буй хуулийн этгээдүүдийн мэдээллийг шилэн дансанд байршуулах талаар холбогдох арга хэмжээ авах.*
5. *Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийж буй дотоод хяналтын үр дүнг үнэлэх, өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тухай бүр тооцож байх.*

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт:

1. *Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хуулийн хугацаанд нь үнэн зөв мэдээлж, дутуу мэдээлсэн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим системд 2016 оны 12-р сарын 20-ны өдрийн дотор нөхөн байршуулж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.*

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Ч.ЭНХТУЯА
АУДИТЫН МЕНЕЖЕР	Б.БАТМӨНХ
ШИНЖЭЭЧ	Ц.УРТНАСАН